



ГОВЬСҮМБЭР АНМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 09 өдөр

дугаар А/70

Баянтал сум

Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх хяналт тавих журам”-ын 3.4.2, 3.4.3, 3.4.4, 6.7, 6.8 дах заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Суманд жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах комиссын хурлаас батлагдсан мал нядалгаа, мах болон дайвар бүтээгдэхүүн ангилан ялгах, савлах чиглэлийн “Говийн шим бренд” төслийг баталсугай

2. Батлагдсан төсөлд шаардагдах 85,000,000.00 (Наян таван сая) төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сангаас олгохыг Нягтлан бодогч / Б.Энхтунгалаг /-д зөвшөөрсүгэй

3. Хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдийн төслийн хэрэгжилт, зээлийн эргэн төлөлт, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Хоршоо, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн / С.Оюунтүлхүүр/-д үүрэг болгосугай



ДАРГА

Г.АНХБАЯР

421220215



ТӨВСҮМБЭР АНМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 05 өдөр

дугаар А/41

Баянтал сум

ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 36.1, захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46.1, Төсвийн тухай хууль 16 дугаар зүйл, Төсвийн шууд захирагч, түүний бүрэн эрхийн тухай хуулийн 6.5.5. Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журамын 2.1.3, 2.1.4, 2.1.5, 2.1.6, 4.1, 4.2 тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс гарах 50,000,000 төгрөгний зардлын задаргааг 1-дүгээр хавсралтаар баталсугай.
2. Тус зардлыг 2022 оны Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Санхүү албаны нягтлан бодогч (Х.Ариунгуа)-д зөвшөөрсүгэй.
3. Тус ажлын хэрэгжилтийг хангуулж хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (В.Гантуяа)-д даалгасугай.

ДАРГА


Г.АНХБАЯР

421220240

Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын
05 өдрийн 1/4 дугаар захирамжийн хавсралт

АЙМГААС ОЛГОСОН 50,000,000 ТӨГРӨГИЙГ
ХУЕААРИЛСАН ТӨСӨВ

№	Төсвийн нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Иргэдийн хуралд тэтгэмж, цалин урамшуулал	1	14,400,000	14,400,000
2	4-р сургуулийн камер	1	10,000,000	10,000,000
3	Талын Илч ОНӨААТҮГ	1	2,099,900	2,099,900
4	Эрүүл мэндийн төв	1	2,389,700	2,389,700
5	Соёлын төв	1	2,389,700	2,389,700
6	4-р цэцэрлэгт нөөтбүүк	1	2,389,700	2,389,700
7	Засаг даргын Тамгын газарт нөөтбүүк	1	3,099,900	3,099,900
8	принтер	1	949,400	949,400
9	перектор	1	2,149,900	2,149,900
10	Шаардлага гарах үед зарцуулахаар засаг даргын нөөцөд үлдээх	1	10,131,800	10,131,800
11	Нийт	11	50,000,000	50,000,000



ГОВЬСҮМБӨР АИМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 31 өдөр

дугаар 172

Баянтал сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1 Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн А/24 тоот захирамжаар “Бигом” ХХК –ны 5 га газар эзэмших эрхийг цуцалсанг “Бигом” ХХК-ны захирал Б.Цэгмэд нь захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргаж маргаантай шүүхээс хэргийг эцэслэн шийдвэрлээгүй байхад “Бигом” ХХК-нь хууль зөрчиж үйл ажиллагаа явуулж байна гэсэн мэдээлэл ирсэний дагуу тус газар дээр хяналт шалгалт хийх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Хэсгийн дарга:

Э.Эрхэмбаатар (Засаг даргын орлогч дарга)

Гишүүд:

Ц.Загарсүрэн (Газрын даамал)


Х.Пүрэвжаргал (Хэсгийн төлөөлөгч)

Э.Түмэн-Эрдэнэ (1-р багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга:

Б.Төгөлдөр (Байгаль орчны байцаагч)

2. Захирамжийн хэрэгжилтийг хангуулж, зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн дарга (Э.Эрхэмбаатар)-д даалгасугай.

ДАРГА  Г.АНХБАЯР